


## МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2018 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 6,516.7 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 6,275.0 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 241.7 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл өмнөх оны мөн үеэс 979.5 тэрбум төгрөгөөр, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 2,616.6 тэрбум төгрөгөөр тус тус буурч сайжирсан байна.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/



2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт тэнцвэржүүлсэн улсын төсвийн орлого 908.7 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого 75.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцвэржүүлсэн орлого 21.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн бол орон нутгийн төсвийн орлого 2.0 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого нь өнгөрсөн оны мөн үеэс 29.4 хувь буюу 1,481.5 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага нь 8.7 хувь буюу 502.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн хэдий ч төсвийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 20.7 пунктээр өндөр байгаа нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 979.5 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

### Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

#### Хүснэгт 1.

/тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	172.5	940.1	1,336.1	142.1	-396.1
Засгийн газрын бонд	332.4	-687.0	-2,183.4	317.8	1,496.5
Засгийн газрын зээл	149.0	1,906.3	496.5	26.0	1,409.9
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	83.0	100.0	100.0	100.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	83.2	0.0	0.0	83.2
Өмч хувьчлал	0.9	32.2	9.1	28.3	23.1
<b>НИЙТ ДҮН</b>	<b>737.9</b>	<b>2,374.9</b>	<b>-241.7</b>	<b>-10.2</b>	<b>2,616.6</b>

Эх сурвалж: Сангийн яам

2018 оны 3 дугаар улирлын байдлаар гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 205.3 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 1,516.4 тэрбум болон гадаад бондын үндсэн төлбөрт 667.0 тэрбум төгрөгийг тус тус төлж, шинээр авсан гадаад төслийн зээлийн хэмжээ 460.9 тэрбум төгрөгт хүрчээ. Шинээр Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд гаргаагүй байна.

## 2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

**Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6,516.7 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 29.4 хувь буюу 1,481.5 тэрбум төгрөгөөр өсч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 19.1 хувь буюу 1,045.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй гарсан байна.**

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр нь авч үзвэл улсын төсөв 23.5 хувь буюу 908.7 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн төсөв 5.3 хувь буюу 75.2 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 7.8 хувь буюу 21.6 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн боловч орон нутгийн төсөв 0.1 хувь буюу 2.0 тэрбум төгрөгөөр тасалджээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт орлого 34.3 хувь буюу 1,219.6 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 15.8 хувь буюу 266.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, харин нийгмийн даатгалын сангийн орлого 2.3 хувь буюу 35.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн орлогын 2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл, төсвийн шатлалаар  
**Хүснэгт 2.** /тэрбум төгрөг/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,306.0	5,444.7	1,952.6	1,950.5	1,412.9	1,488.1	277.7	299.3
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	83.2	180.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	351.7	485.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,871.1	4,779.7	1,952.6	1,950.5	1,412.9	1,488.1	277.7	299.3
<b>Татварын орлого</b>	2,837.5	3,849.5	801.9	795.4	948.9	1,024.0	277.7	299.3
Орлогын албан татвар	508.0	867.7	544.7	546.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	948.9	1,024.0	277.7	299.3
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	101.9	105.4	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,099.3	1,533.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	505.2	550.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	9.3	9.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	403.7	488.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	312.1	398.8	155.4	143.9	0.0	0.0	0.0	0.0
<b>Татварын бус орлого</b>	1,033.6	930.3	1,150.6	1,155.2	464.1	464.1	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	565.4	574.4	135.4	140.5	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.7	0.4	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	251.6	169.8	1.7	1.4	464.1	464.1	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	216.7	186.1	1,012.9	1,012.9	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

**График 2.** Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/




Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 88.8 хувийг татварын орлого, 11.2 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 31.8 хувь буюу 1,395.2 тэрбум, татварын бус орлого 13.4 хувь буюу 86.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

**Татварын орлого 5,786.1 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 23.7 хувь буюу 1,109.1 тэрбум төгрөгөөр давж биелжээ.**

Татварын орлогын 24.4 хувийг орлогын албан татвар, 19.7 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.8 хувийг хөрөнгийн албан татвар, 26.5 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.5 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 8.4 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 9.4 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

**График 3.** Татварын орлого /тэрбум төгрөг/



Татварын орлогын бүх төрлүүд төлөвлөснөөс давж биелжээ. Түүн дотор: нэгдсэн төсвийн орлогын албан татвар 34.3 хувь /361.1 тэрбум.төг/, нийгмийн даатгалын орлого 10.0 хувь /103.7 тэрбум.төг/, хөрөнгийн албан татвар 3.4 хувь /3.5 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 39.5 хувь /434.7 тэрбум.төг/, онцгой албан татвар 9.0 хувь буюу /45.6 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 2.2 хувь /0.2 тэрбум.төг/ гадаад үйл ажиллагааны орлого 21.1 хувь /85.0 тэрбум.төг/, бусад татвар, төлбөр хураамж 16.1 хувь /75.3 тэрбум.төг/-аар тус тус давж биелэв.

**Давж биелсэн нийт татварын орлогын өсөлтийн 39.2 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 32.6 хувийг орлогын албан татвар, 9.4 хувийг нийгмийн даатгалын орлого, 7.7 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 6.8 хувийг бусад татвар, төлбөр хураамжийн орлого, 4.1 хувийг онцгой албан татвар, 0.3 хувийг хөрөнгийн албан татвар эзэлжээ.**


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2018 оны 3 дугаар улирлын байдлаар татварын орлого 1,395.2 тэрбум төгрөг буюу 31.8 хувиар өсөхөд тусгай зориулалтын орлого 0.3 тэрбум (2.7%) төгрөгөөр буурсан ч орлогын албан татвар 328.6 тэрбум (30.3%), нийгмийн даатгалын орлого 213.9 тэрбум (23.1%), хөрөнгийн албан татвар 14.0 тэрбум (15.3%), нэмэгдсэн өртгийн албан татвар 380.1 тэрбум (32.9%), онцгой албан татвар 190.4 тэрбум (52.8%), гадаад үйл ажиллагааны орлого 137.4 тэрбум (39.1%), бусад татвар, төлбөр, хураамж 131.1 тэрбум (31.9%) төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

*Татварын орлогын өсөлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27.2 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 23.5 хувийг орлогын албан татвар, 13.6 хувийг онцгой албан татвар, 15.3 хувийг нийгмийн даатгалын орлого, 9.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 9.4 хувийг бусад татвар, төлбөр, хураамж, 1.0 хувийг хөрөнгийн албан татвар эзэлж байна.*

*Татварын бус орлого 730.5 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 13.4 хувь буюу 86.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төлөвлөснөөс 63.3 тэрбум төгрөг буюу 8.0 хувиар дутуу төвлөрсөн байна.*

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд төсөвт байгууллагын өөрийн орлого 58.6 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ. Харин хувьцааны ногдол ашиг 15.1 тэрбум, хүүгийн орлого 22.7 тэрбум, торгуулийн орлого 15.9 тэрбум, газрын тосны орлого 12.2 тэрбум, бусад орлого 6.9 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс илүү төвлөрчээ.

График 4. Татварын бус орлогын бүтэц /хувиар/



Татварын бус орлогын 97.9 хувийг нийтлэг татварын бус орлого, 2.1 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлсэн байна. Нийтлэг татварын бус орлогын 28.3 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 24.7 хувийг газрын тосны орлого, 17.2 хувийг навигацгийн орлого, 10.6 хувийг хувьцааны ногдол ашиг, 7.9 хувийг бусад орлого, 6.0 хувийг торгуулийн орлого, 5.1 хувийг хүүгийн орлого, 0.2 хувийг түрээсийн орлого тус тус эзэлж байна.

*Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн дагуу 22 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 10 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн бол үлдсэн 12 нь 2.9-100.0 хувь дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна. Татварын ерөнхий газар 62.9 хувь, Гаалийн ерөнхий газар 22.4 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.*

2018 оны 3 дугаар улиралд улсын төсвийн ерөнхийлөн захирагч,  
түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

## Хүснэгт 3.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны	2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл			
	мөн үеийн	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Сангийн сайд</b>	<b>3,390,991.9</b>	<b>3,630,461.1</b>	<b>4,766,291.1</b>	<b>1,135,830.0</b>	<b>131.3</b>
Татварын ерөнхий газар	1,930,988.5	1,604,353.0	2,613,057.9	1,008,704.8	162.9
Үүнээс: Тогтворжуулалтын санд	204,136.8	180,235.3	179,968.2	-267.1	99.9
Ирээдүйн өв санд	251,742.5	303,895.6	485,044.1	181,148.5	159.6
Гаалийн ерөнхий газар	1,361,167.1	1,601,200.7	1,960,485.2	359,284.5	122.4
Сангийн яам	37,781.9	331,099.0	128,443.3	-202,655.7	38.8
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	5,734.9	73,960.3	58,219.5	-15,740.8	78.7
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	8,176.1	17,171.2	1,576.7	-15,594.5	9.2
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	47,143.4	2,676.7	4,508.5	1,831.7	168.4
<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b>	<b>7,199.1</b>	<b>2,684.9</b>	<b>1,592.7</b>	<b>-1,092.2</b>	<b>59.3</b>
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	7,199.1	2,684.9	1,592.7	-1,092.2	59.3
<b>Монгол Улсын Ерөнхий аудитор</b>	<b>0.0</b>	<b>87.6</b>	<b>290.8</b>	<b>203.2</b>	<b>332.0</b>
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	87.6	290.8	203.2	332.0
<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>25,972.1</b>	<b>96,357.9</b>	<b>16,029.9</b>	<b>-80,328.0</b>	<b>16.6</b>
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	842.8	1,900.0	1,800.0	-100.0	94.7
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	9,542.5	91,842.5	11,598.8	-80,243.7	12.6
Үүнээс: Ирээдүйн өв санд	0.0	47,842.5	0.0	-47,842.5	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	15,586.8	2,615.4	2,631.1	15.7	100.6
<b>Монгол Улсын Шадар сайд</b>	<b>30,909.3</b>	<b>8,111.0</b>	<b>13,502.3</b>	<b>5,391.3</b>	<b>166.5</b>
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	2,816.3	1,921.8	2,640.9	719.0	137.4
Стандарт, хэмжил зүйн газар	2,173.6	1,966.4	2,884.4	918.0	146.7
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	7,294.3	2,006.0	1,986.5	-19.5	99.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	18,625.1	2,216.8	5,990.5	3,773.7	270.2
<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>	<b>88,001.5</b>	<b>34,207.8</b>	<b>36,788.9</b>	<b>2,581.1</b>	<b>107.5</b>
Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	14,780.8	15,055.1	13,929.8	-1,125.3	92.5
Цагдаагийн ерөнхий газар	1,182.4	2,615.6	1,578.1	-1,037.6	60.3
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	625.5	0.0	-625.5	0.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	15,264.7	4,126.4	4,034.5	-91.9	97.8
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	56,773.5	11,785.2	17,246.5	5,461.3	146.3
<b>Гадаад харилцааны сайд</b>	<b>19,085.0</b>	<b>17,555.8</b>	<b>20,746.1</b>	<b>3,190.3</b>	<b>118.2</b>
Дипломат төлөөлөгчийн газрууд	17,611.9	16,393.3	20,174.0	3,780.6	123.1
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,473.1	1,162.5	572.1	-590.4	49.2
<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b>	<b>136,593.4</b>	<b>125,556.4</b>	<b>130,136.6</b>	<b>4,580.2</b>	<b>103.6</b>
Иргэний нисэхийн ерөнхий газар	102,760.8	122,972.8	122,975.0	2.2	100.0
Зам, тээврийн хөгжлийн яам	142.5	148.4	148.3	-0.1	99.9
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	5,105.2	822.7	936.1	113.4	113.8
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	28,584.9	1,612.5	6,077.2	4,464.7	376.9
<b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b>	<b>221,805.9</b>	<b>221,844.0</b>	<b>215,380.5</b>	<b>-6,463.5</b>	<b>97.1</b>
Ашигт малтмал, газрын тосны газар	189,267.1	217,893.0	213,721.3	-4,171.7	98.1
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	32,538.8	3,950.9	1,659.2	-2,291.8	42.0
<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>191,660.6</b>	<b>58,257.9</b>	<b>26,212.0</b>	<b>-32,045.9</b>	<b>45.0</b>
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	420.0	390.5	410.0	19.5	105.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	1,606.4	473.3	355.5	-117.9	75.1
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	9,049.2	0.0	-9,049.2	0.0

Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	189,634.2	48,344.9	25,446.5	-22,898.4	52.6
<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	<b>589,228.4</b>	<b>79,066.5</b>	<b>147,481.9</b>	<b>68,415.4</b>	<b>186.5</b>
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	226,850.0	28,767.7	101,529.5	72,761.8	352.9
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	34,212.5	1,414.6	103.0	-1,311.7	7.3
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	328,165.9	48,884.1	45,849.4	-3,034.8	93.8
<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>735,372.8</b>	<b>175,329.7</b>	<b>167,021.0</b>	<b>-8,308.7</b>	<b>95.3</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	648,159.3	151,313.4	147,060.2	-4,253.2	97.2
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	4,702.2	2,015.0	317.4	-1,697.6	15.8
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	82,511.3	22,001.3	19,643.4	-2,357.9	89.3
<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b>	<b>37,241.6</b>	<b>9,686.4</b>	<b>5,360.5</b>	<b>-4,325.9</b>	<b>55.3</b>
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	35,058.6	9,435.4	4,616.0	-4,819.4	48.9
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	2,183.0	250.9	744.5	493.5	296.7
<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b>	<b>390.3</b>	<b>372.1</b>	<b>541.0</b>	<b>169.0</b>	<b>145.4</b>
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	265.2	415.6	150.4	156.7
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	390.3	106.9	125.4	18.5	117.3
<b>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд</b>	<b>25,410.2</b>	<b>60,543.9</b>	<b>6,059.6</b>	<b>-54,484.3</b>	<b>10.0</b>
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	2,013.8	56,969.1	1,955.2	-55,013.8	3.4
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	23,396.4	3,574.8	4,104.4	529.5	114.8
<b>Барилга, хот байгуулалтын сайд</b>	<b>763.3</b>	<b>1,632.0</b>	<b>1,065.0</b>	<b>-567.0</b>	<b>65.3</b>
Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	763.3	1,288.8	1,065.0	-223.8	82.6
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	343.2	0.0	-343.2	0.0
<b>Батлан хамгаалахын сайд</b>	<b>152,178.5</b>	<b>39,947.1</b>	<b>19,267.2</b>	<b>-20,679.9</b>	<b>48.2</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	17,068.3	5,011.0	4,258.2	-752.8	85.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	135,110.2	34,936.1	15,009.0	-19,927.1	43.0
<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b>	<b>648.0</b>	<b>45.0</b>	<b>77.7</b>	<b>32.7</b>	<b>172.8</b>
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	648.0	45.0	77.7	32.7	172.8
<b>Санхүүгийн зохицуулах хороо</b>	<b>3,084.0</b>	<b>578.7</b>	<b>580.2</b>	<b>1.5</b>	<b>100.3</b>
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	3,084.0	578.7	580.2	1.5	100.3
<b>Үндэсний статистикийн хорооны дарга</b>	<b>13.3</b>	<b>24.4</b>	<b>0.0</b>	<b>-24.4</b>	<b>0.0</b>
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	24.4	0.0	-24.4	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	13.3	0.0	0.0	0.0	0.0
<b>Улсын ерөнхий прокурор</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>Эрчим хүчний сайд</b>	<b>0.0</b>	<b>3,766.0</b>	<b>0.0</b>	<b>-3,766.0</b>	<b>0.0</b>
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	3,766.0	0.0	-3,766.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

### 3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 7,845.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 80.0 хувийг ашиглаж 1,570.8 тэрбум төгрөг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 502.0 тэрбум төгрөг буюу 8.7 хувиар өсч 6,275.0 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.



Нэгдсэн төсвийн зарлагын 2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл /*төсвийн шатлалаар/*  
*Хүснэгт 4.* /*тэрбум төгрөг/*

	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,051.0	4,918.8	2,231.7	1,791.7	1,350.3	1,345.4	256.3	220.1
НИЙТ ЗАРЛАГА	5,808.3	4,650.9	2,200.2	1,776.6	1,350.3	1,345.4	256.3	220.1
УРСГАЛ ЗАРДАЛ	4,536.3	4,065.0	1,727.1	1,519.3	1,350.3	1,345.4	256.3	220.1
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,629.0	1,339.8	1,123.7	1,005.6	13.8	12.9	3.3	2.1
Зээлийн үйлчилгээний төлбөр	880.3	743.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Татаас	528.3	521.7	77.8	69.5	0.0	0.0	35.6	26.3
Урсгал шилжүүлэг	1,498.6	1,459.9	525.6	444.2	1,336.4	1,332.4	217.4	191.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,272.1	585.9	473.0	257.2	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	242.7	267.9	31.5	15.1	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-2,179.9	-139.1	-279.1	158.8	62.7	142.7	21.4	79.2

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 1,132.2 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 440.0 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 4.9 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 36.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 346.5 тэрбум, орон нутгийн төсвийн зардал 239.2 тэрбум төгрөгөөр тус тус өсч, нийгмийн даатгалын сангийн зардал 35.9 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеэс 8.7 хувь буюу 502.0 тэрбум төгрөгөөр өсөхөд урсгал зардал 6.7 хувь буюу 323.9 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 4.6 хувь буюу 36.9 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 99.5 хувь буюу 141.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бараа, ажил үйлчилгээний зардал 5.1 хувь буюу 108.8 тэрбум, урсгал шилжүүлэг 15.8 хувь буюу 276.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, зээлийн үйлчилгээний төлбөр 4.3 хувь буюу 33.6 тэрбум, татаас 15.4 хувь буюу 28.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

*Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 33.6 тэрбум төгрөгөөр, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 136.8 тэрбум төгрөгөөр буюу 15.5 хувиар бага байгаа нь тайлант хугацаанд улсын төсөвт нөлөөлөх хүүгийн зардал буурах төлвийг харуулж байна.*

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл  
 /Зардлын эдийн засгийн ангиллаар/

*Хүснэгт 5.*

/*тэрбум төгрөг/*

	ӨО-ны мөн үеийн	2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,773.0</b>	<b>7,845.7</b>	<b>6,275.0</b>	<b>80.0</b>	<b>1,570.8</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>5,631.1</b>	<b>7,571.5</b>	<b>5,991.9</b>	<b>79.1</b>	<b>1,579.6</b>

УРСГАЛ ЗАРДАЛ	4,824.9	5,826.4	5,148.8	88.4	677.7
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,120.1</b>	<b>2,631.6</b>	<b>2,228.9</b>	<b>84.7</b>	<b>402.7</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,292.0	1,390.1	1,337.9	96.2	52.3
Үндсэн цалин	1,074.3	1,020.1	1,004.1	98.4	16.0
Нэмэгдэл	129.3	262.2	238.5	91.0	23.7
Унаа хоолны хөнгөлөлт	26.8	35.3	31.1	88.0	4.2
Урамшуулал	33.5	47.1	40.0	85.0	7.1
Гэрээт ажлын хөлс	28.2	25.5	24.2	94.8	1.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэврийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэмжийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
ҮОМШӨ-ний даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Ажилгүйдлийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Эрүүл мэндийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145.1	177.4	152.0	85.7	25.4
Гэрэл, цахилгаан	29.3	37.3	32.4	86.7	5.0
Түлш, халаалт	86.0	104.5	90.4	86.5	14.1
Цэвэр, бохир ус	14.9	18.9	15.6	82.9	3.2
Байрны гүрээс	14.9	16.7	13.6	81.5	3.1
Хангамж, бараа материалын зардал	79.3	95.6	84.8	88.7	10.8
Бичиг хэрэг	6.4	8.4	7.3	86.4	1.1
Тээвэр, шатахуун	29.0	33.9	31.6	93.0	2.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7.6	10.2	7.9	77.2	2.3
Ном, хэвлэл	2.3	5.1	3.2	63.1	1.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	28.2	30.1	27.9	92.8	2.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5.8	7.9	7.0	88.0	1.0
Нормативт зардал	160.7	211.1	185.6	0.0	25.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	76.1	104.8	96.6	92.2	8.2
Хоол, хүнс	64.6	76.8	66.2	86.2	10.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	20.0	29.4	22.8	77.6	6.6
Эд хогшил, урсгал засварын зардал	34.4	55.5	41.9	75.5	13.6
Багаж, техник, хэрэгсэл	10.3	16.8	12.2	72.1	4.7
Тавилга	1.3	3.2	1.6	51.1	1.5
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.5	1.6	0.9	60.4	0.6
Урсгал засвар	22.2	33.9	27.2	80.2	6.7
Томилолт, зочны зардал	13.6	23.0	17.2	74.6	5.8
Гадаад албан томилолт	5.1	8.1	7.1	87.1	1.1
Дотоод албан томилолт	6.8	12.2	7.9	64.5	4.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	1.7	2.7	2.2	82.5	0.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	216.6	422.5	233.0	55.2	189.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196.6	391.7	212.8	54.3	179.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.6	1.4	0.9	63.5	0.5
Даатгалын үйлчилгээ	8.5	9.2	8.1	88.6	1.0
Тээврийн хэрэгслийн татвар	0.5	0.6	0.5	73.1	0.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.1	0.2	0.2	68.6	0.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3.6	9.7	5.4	56.0	4.2
Газрын төлбөр	0.7	1.1	0.6	59.3	0.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.9	1.4	0.7	52.4	0.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5.0	7.2	3.9	53.3	3.4
Бараа үйлчилгээний бусад зардал	178.5	256.4	176.6	68.9	79.8
Бараа үйлчилгээний бусад зардал	157.8	225.9	155.2	68.7	70.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20.7	30.5	21.4	70.1	9.1
<b>ХҮҮ</b>	<b>777.1</b>	<b>880.3</b>	<b>743.5</b>	<b>84.5</b>	<b>136.8</b>
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	365.9	509.9	456.1	89.4	53.8
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	411.2	370.4	287.4	77.6	83.0
<b>ТАТААС</b>	<b>181.5</b>	<b>177.7</b>	<b>153.5</b>	<b>86.4</b>	<b>24.2</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	16.9	23.5	23.1	98.4	0.4



Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	164.6	154.1	130.3	84.5	23.8
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,746.1</b>	<b>2,136.8</b>	<b>2,022.8</b>	<b>94.7</b>	<b>114.0</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	12.9	79.0	51.1	64.7	27.9
Засгийн газрын дотоод шилжүүлэг	9.3	71.3	46.9	65.8	24.4
Засгийн газрын гадаад шилжүүлэг	3.6	7.6	4.2	54.6	3.5
Бусад урсгал шилжүүлэг	1,733.3	2,057.9	1,971.7	95.8	86.2
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	1,175.1	1,336.6	1,332.5	99.7	4.1
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	349.6	461.8	441.3	95.6	20.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3.2	5.0	3.6	72.3	1.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	98.9	139.6	105.7	75.7	33.9
Ээлжийн амралтаар нугаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	25.5	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49.9	66.9	49.7	74.4	17.1
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	52.6	38.1	34.3	89.9	3.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3.9	9.9	4.7	47.0	5.3
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>806.2</b>	<b>1,745.1</b>	<b>843.2</b>	<b>48.3</b>	<b>901.9</b>
Барилга байгууламж	592.5	1,067.6	445.5	41.7	622.2
Их засвар	39.4	73.8	39.2	53.1	34.6
Тоног төхөөрөмж	33.7	276.6	135.0	48.8	141.6
Бусад хөрөнгө	120.9	318.1	220.5	69.3	97.6
Стратегийн нөөц хөрөнгө	19.8	8.9	3.0	33.3	5.9
Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	-	0.0
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>141.9</b>	<b>274.2</b>	<b>283.0</b>	<b>103.2</b>	<b>-8.8</b>
Эргэж төлөгдөх зээл	92.9	181.5	208.7	115.0	-27.2
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	0.0	0.0	0.0	-	0.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	49.0	92.7	74.4	80.2	18.3


Эх сурвалж: Сангийн Яам

**Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 82.1 хувь болж, өнгөрсөн оноос 1.5 пунктээр буурсан байна.**

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 82.1 хувь буюу 5,148.8 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 43.3 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 14.4 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.0 хувийг татаас, 39.3 хувийг урсгал шилжүүлэг эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 323.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: зээлийн үйлчилгээний төлбөр 33.6 тэрбум, татаас 28.0 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч бараа, үйлчилгээний зардал 108.8 тэрбум, урсгал шилжүүлэг 276.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

График 5. Урсгал зардлын бүтэц /хувиар/



**Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар 31 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2018 оны эхний 3 дугаар улирлын гүйцэтгэлээр тэдгээрийн батлагдсан улсын төсвийн нийт зарлагын төсөв 1,132.2 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.**

Улсын төсвийн нийт зарлагын 23.5 хувийг Сангийн сайдын багц, 18.2 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багц, 9.5 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 18.6 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 6.5 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, 3.0 хувийг Батлан хамгаалахын сайдын багц, 4.6 хувийг Зам, тээврийн хөгжлийн сайд, 3.5 хувийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц, үлдэх 12.6 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын зардал эзэлж байна.

## Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

## Хүснэгт 6.

/сая төгрөг/


Төсвийн ерөнхийлөн захирагч	2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	4,323.1	3,708.5	614.6	85.8
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	27,922.4	21,009.8	6,912.5	75.2
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	181,628.7	146,698.2	34,930.5	80.8
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	30,357.7	14,643.1	15,714.6	48.2
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	55,545.0	44,905.3	10,639.7	80.8
САНГИЙН САЙД	1,407,660.0	1,153,635.7	254,024.4	82.0
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	184,361.1	147,532.6	36,828.5	80.0
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	589,818.7	468,762.5	121,056.2	79.5
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	1,708.2	1,591.1	117.1	93.1
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	3,028.3	2,467.0	561.3	81.5
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	36,855.3	33,913.0	2,942.4	92.0
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	21,457.8	20,593.1	864.7	96.0
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	1,560.8	1,468.4	92.4	94.1
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	9,187.8	8,229.7	958.1	89.6
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	7,582.7	5,623.3	1,959.4	74.2
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	3,104.8	2,156.6	948.1	69.5
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	591.6	576.0	15.6	97.4
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	515.7	333.2	182.5	64.6
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	104,822.2	78,669.7	26,152.5	75.1
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	929.9	749.5	180.4	80.6
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	853.7	698.4	155.3	81.8
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	12,360.3	7,885.5	4,474.8	63.8
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	69,204.9	51,444.0	17,760.9	74.3
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	371,515.4	320,592.4	50,923.0	86.3
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	118,777.2	69,509.5	49,267.7	58.5
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	1,204,611.9	893,175.4	311,436.5	74.1
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	320,864.7	225,151.9	95,712.7	70.2
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	20,896.8	13,500.5	7,396.4	64.6
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	142,115.6	172,822.5	-30,707.0	121.6
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	142,618.3	91,158.6	51,459.7	63.9
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	974,218.1	915,626.4	58,591.7	94.0
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>6,050,998.7</b>	<b>4,918,831.4</b>	<b>1,132,167.3</b>	<b>81.3</b>

Эх сурвалж: Сангийн яам

#### 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 543.1 тэрбум төгрөг төсөвлөснөөс 176.8 тэрбум төгрөг зарцуулж, 32.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

График 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөгөөр/



Улсын төсвийн хөрөнгөөр 2018 оны 3 дугаар улиралд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 543.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс 176.8 тэрбум төгрөг зарцуулсан нь төлөвлөсөн хэмжээнээс 366.4 тэрбум төгрөгөөр буюу 67.5 хувиар дутуу зарцуулагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагчаар/

#### Хүснэгт 7.

/сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ	2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл				
		Төсөвт өртөг	Төлөв.	Гүйцэт.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	770.7	770.7	770.7	604.3	166.4	78.4
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	1,913.3	1,913.3	1,913.3	538.8	1,374.5	28.2
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	5,685.3	3,762.8	3,033.3	1,205.5	1,827.8	39.7
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	12,695.2	6,006.4	6,006.4	1,534.5	4,471.9	25.5
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	23,920.9	11,881.8	11,232.9	4,570.7	6,662.2	40.7
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	12,789.5	10,389.5	6,789.5	2,226.3	4,563.2	32.8
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	1,800.0	1,800.0	1,800.0	1,377.5	422.5	76.5
САНГИЙН САЙД	78,098.1	32,810.0	19,770.0	7,737.1	12,032.9	39.1
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	59,590.9	37,390.0	31,990.0	20,803.4	11,186.6	65.0
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	36,723.3	17,340.0	15,840.0	2,916.1	12,923.9	18.4
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	19,417.4	3,599.5	3,599.5	2,239.8	1,359.7	62.2
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	430,501.9	80,338.4	69,248.2	21,747.8	47,500.5	31.4
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	739,860.0	262,817.6	212,275.6	54,025.7	158,249.9	25.5
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	342,951.3	80,796.9	62,757.9	32,089.7	30,668.1	51.1
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	3,980.0	3,980.0	3,301.6	139.9	3,161.7	4.2
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	41,521.3	27,818.5	19,505.0	3,291.9	16,213.1	16.9
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	151,489.7	37,661.9	26,661.9	7,041.4	19,620.5	26.4
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	193,319.5	60,754.8	45,159.9	11,587.7	33,572.1	25.7
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	195.6	195.6	195.6	185.6	10.0	
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	340.0	340.0	340.0	259.6	80.4	0.0
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	1,562.0	452.0	452.0	160.8	291.2	35.6
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	500.0	500.0	500.0	498.0	2.0	99.6
<b>НИЙТ</b>	<b>2,159,625.8</b>	<b>683,319.8</b>	<b>543,143.2</b>	<b>176,782.1</b>	<b>366,361.1</b>	<b>32.5</b>

Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 82.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 79.0 тэрбум төгрөг зарцуулж 95.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барих-шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2018 оны 3 дугаар улирлын санхүүжилтийн гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагчдаар/

### Хүснэгт 8.

/сая төгрөг/


ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР, ХҮЧИН ЧАДАЛ, БАЙРШИЛ	ТӨСӨВТ ӨРТӨГ	2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл		ЗӨРҮҮ	ХУВЬ
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД</b>	<b>82,884.4</b>	<b>82,884.4</b>	<b>78,997.8</b>	<b>3,886.7</b>	<b>95.3</b>
<b>Үндэсний хөгжлийн газар</b>	<b>82,884.4</b>	<b>82,884.4</b>	<b>78,997.8</b>	<b>3,886.7</b>	<b>95.3</b>
<i>Концессын төслийн эргэн төлөлт</i>	<b>82,884.4</b>	<b>82,884.4</b>	<b>78,997.8</b>	<b>3,886.7</b>	<b>95.3</b>
<b>I.Хөрөнгө оруулалт</b>	<b>82,884.4</b>	<b>82,884.4</b>	<b>78,997.8</b>	<b>3,886.7</b>	<b>95.3</b>
<b>Шилжих</b>	<b>82,884.4</b>	<b>82,884.4</b>	<b>78,997.8</b>	<b>3,886.7</b>	<b>95.3</b>
- Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам	32,324.4	32,324.4	30,816.1	1,508.3	95.3
- Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам	48,715.8	48,715.8	46,442.7	2,273.2	95.3
- Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь гүүрийн барилгын ажил	584.9	584.9	539.9	45.0	92.3
- Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл Шинэ-Идэр сум/	670.0	670.0	609.8	60.2	91.0
- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор/	589.3	589.3	589.3	0.0	100.0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>82,884.4</b>	<b>82,884.4</b>	<b>78,997.8</b>	<b>3,886.7</b>	<b>95.3</b>

Эх сурвалж: Сангийн яам

### 5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сан

2018 оны 3 дугаар улиралд эрүүл мэндийн даатгалын санд 299.3 тэрбум, нийгмийн даатгалын санд 1,488.1 тэрбум, нийт 1,787.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 263.6 тэрбум төгрөг буюу 17.3 хувиар өссөн байна.

График 7. Эрүүл мэндийн нийгмийн даатгалын сангийн орлого /тэрбум төгрөг/




**Нийгмийн даатгалын сангийн орлого:** 2018 оны 3 дугаар улиралд нийгмийн даатгалын санд нийт 1,488.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 5.3 хувь буюу 75.2 тэрбум төгрөгөөр давж биелэн орлогын гүйцэтгэл 105.3 хувьтай гарчээ.

Тайлант хугацаанд ажил олгогч, даатгуулагчаас нийгмийн даатгалын санд нийт 1,024.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, мөн тус санд улсын төсвөөс 464.1 тэрбум төгрөгийн татаас олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг сангийн төрлөөр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын санд 768.6 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 96.1 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын санд 128.3 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 31.1 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:** Эрүүл мэндийн даатгалын санд 2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр 299.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 7.8 хувь буюу 21.6 тэрбум төгрөгөөр давж биелснээр орлогын гүйцэтгэл 107.8 хувьтай гарчээ.

**Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн зарлага:**

**График 8.** Эрүүл мэнд нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөг/




2018 оны 3 дугаар улирлын байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлага 220.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн нийт зарлага 1,345.4 тэрбум, нийт 1,565.5 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 184.2 тэрбум төгрөг буюу 13.3 хувиар өссөн байна. Үүнд: тэтгэврийн даатгалын сангийн зарлага 146.7 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 12.3 тэрбум төгрөг буюу 17.0 хувиар нэмэгдэж, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 4.6 тэрбум төгрөг буюу 15.1 хувиар тус тус нэмэгдэж, ажилгүйдлийн даатгалын

сангийн зарлага 2.6 тэрбум төгрөг буюу 9.8 хувиар буурчээ.

**Нийгмийн даатгалын сангийн зарлага:** 2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр тус сангийн нийт зарлага 1,345.4 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 4.9 тэрбум төгрөг буюу 0.4 хувиар дутуу зарцуулагдсан байна.

**График 9.** Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын бүтэц



2018 оны 3 дугаар улирлын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч иргэдийн тэтгэвэрт болон бусад зардалд нийт 1,204.3 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсэн ба амаржсаны, оршуулгын тэтгэмж болон бусад зардалд 84.6 тэрбум төгрөг, ҮОМШӨ-

ний даатгалын сангаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэр, сувиллын болон бусад зардалд 34.9 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж болон бусад зардалд 24.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага:** 2018 оны 3 дугаар улиралд эрүүл мэндийн даатгалын сангаас 256.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 220.1 тэрбум төгрөгийг зарцуулсанаар тус сангийн гүйцэтгэл 85.9 хувьтай гарчээ.



### 5. Орон нутгийн төсөв


**2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 440.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.**

2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 1,950.5 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн дүнгээс 0.1 хувь буюу 2.0 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Орон нутгийн төсвийн нийт зарлага 1,791.7 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 19.7 хувь буюу 440.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, орон нутгийн төсвийн тэнцэл 158.8 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 15.8 хувиар буюу 266.3 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 15.4 хувь буюу 239.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 48.1 хувийг орон нутгийн төсвийн орлого, 7.2 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 41.2 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 3.4 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 140.9 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.

**График 10. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /хувиар/**



Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

**Хүснэгт 9.**

	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	12,340.7	12,340.7	100.0	29,055.6	29,055.6	100.0	2,726.3	2,726.3	100.0
Баян-Өлгий	11,339.2	11,339.2	100.0	35,206.7	35,206.7	100.0	3,708.4	3,708.4	100.0
Баянхонгор	12,411.9	12,411.9	100.0	29,098.2	29,098.2	100.0	2,853.6	2,853.6	100.0
Булган	0.0	0.0	0.0	22,128.0	22,128.0	100.0	1,758.7	1,758.7	100.0
Говьсүмбэр	0.0	0.0	0.0	5,949.9	5,948.1	100.0	502.9	502.9	100.0
Говь-Алтай	8,102.8	8,102.8	100.0	24,632.9	24,632.9	100.0	2,555.4	2,555.4	100.0
Дархан-Уул	0.0	0.0	0.0	24,491.1	24,491.1	100.0	2,225.6	2,225.6	100.0
Дорноговь	0.0	0.0	0.0	22,059.8	22,059.8	100.0	2,488.1	2,488.1	100.0
Дорнод	3,708.0	3,708.0	100.0	22,511.9	22,511.9	100.0	2,754.2	2,754.2	100.0
Дундговь	5,395.6	5,395.6	100.0	17,890.2	17,890.2	100.0	1,580.8	1,580.8	100.0
Завхан	9,185.9	9,185.9	100.0	27,303.7	27,303.7	100.0	2,614.7	2,614.7	100.0
Орхон	0.0	0.0	0.0	24,674.4	24,674.4	100.0	2,664.1	2,664.1	100.0
Өвөрхангай	11,813.2	11,813.2	100.0	33,125.3	33,125.3	100.0	3,315.3	3,315.3	100.0
Өмнөговь	0.0	0.0	0.0	21,761.9	21,761.9	100.0	2,580.6	2,580.6	100.0
Сүхбаатар	5,058.2	5,058.2	100.0	21,049.8	21,049.8	100.0	2,013.4	2,013.4	100.0
Сэлэнгэ	5,300.0	5,300.0	100.0	34,765.5	34,765.5	100.0	2,907.8	2,907.8	100.0
Төв	7,709.9	7,709.9	100.0	31,975.2	31,975.2	100.0	2,439.2	2,439.2	100.0
Увс	13,500.0	13,500.0	100.0	29,597.1	29,597.1	100.0	3,178.5	3,178.5	100.0



Улаанбаатар	0.0	0.0	0.0	253,219.1	253,219.1	100.0	11,062.5	11,062.5	100.0
Ховд	9,448.6	9,448.6	100.0	28,824.9	28,824.9	100.0	3,327.7	3,327.7	100.0
Хөвсгөл	15,829.7	15,829.7	100.0	40,971.6	40,971.6	100.0	4,123.9	4,123.9	100.0
Хэнтий	9,749.3	9,749.3	100.0	25,947.3	25,947.3	100.0	2,358.4	2,358.4	100.0
<b>ДҮН</b>	<b>140,892.9</b>	<b>140,892.9</b>	<b>100.0</b>	<b>806,240.1</b>	<b>806,238.3</b>	<b>100.0</b>	<b>65,740.2</b>	<b>65,740.2</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Сангийн Яам

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 806.2 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад олгосон байна.

2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 65.7 тэрбум төгрөгийг шилжүүлж, аймаг орон нутагт хуваарилсан нь төлөвлөсөн хэмжээгээр буюу 100.0 хувь зарцуулагдсан байна.

Орон нутгийн орлогыг зарим аймгуудаар харуулбал, Архангай аймаг 483.2 сая, Баян-Өлгий аймаг 178.6 сая, Булган аймаг 530.5 сая, Говьсүмбэр аймаг 214.9 сая, Дорноговь аймаг 209.9 сая, Завхан аймаг 1,143.0 сая, Орхон аймаг 7,052.5 сая, Сүхбаатар аймаг 6,680.5 сая, Төв аймаг 2,778.1 сая, Ховд аймаг 1,312.7 сая, Хөвсгөл аймаг 552.4 сая, Хэнтий аймаг 2,214.8 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн дүнгээс давж биелсэн байна.

## ДУГНЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлт өгөхөөр байна. Үүнд:

**Төсвийн орлогын хувьд:** 2018 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 6,516.7 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 1,045.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн, өмнөх оны мөн үеэс 1,481.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл 2018 оны эхний 1 дүгээр улиралд **9.7** хувиар, эхний хагас жилд **16.7** хувиар, эхний 7 сард **13.2** хувиар, эхний 8 сард **18.0** хувиар, 3 дугаар улирлын байдлаар **19.1** хувиар тус тус давж биелсэн байна.
- Өнгөрсөн оны мөн үеэс нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2018 оны 3 дугаар улиралд **29.4** хувь буюу **1,481.5** тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө биелэхэд татварын орлогын өсөлт голлон нөлөөлсөн байна. Үүнд: Татварын орлого 2018 оны эхний 1 дүгээр улиралд **13.7** хувь буюу **194.7** тэрбум, эхний хагас жилд 21.1 хувь буюу **637.4** тэрбум, эхний 7 сард **631.9** тэрбум төгрөг, эхний 8 сард **929.8** тэрбум төгрөг, 3 дугаар улирлын байдлаар **23.7** хувь буюу **1,109.1** тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн. Тайлант хугацаанд бүх төрлийн татварын орлого давж биелжээ.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 2018 оны 1 дүгээр улиралд **85.0** хувь, эхний хагас жилд **91.6** хувь, эхний 7 сард **93.2** хувь, эхний 8 сард **94.2** хувь, 3 дугаар улирлын байдлаар **92.0** хувийн биелэлттэй гарчээ. Татварын бус орлого дутуу биелэхэд төсөвт байгууллагын өөрийн орлого болон тусламжийн орлого дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлсөн байна.

**Төсвийн нийт зарлагын хувьд:** Нэгдсэн төсвийн нийт зарлага 2018 оны 1 дүгээр улиралд **841.7** тэрбум төгрөгөөр, эхний хагас жилийн байдлаар **1,253.7** тэрбум төгрөгөөр буюу 23.3 хувиар, эхний 7 сард **1,542.8** тэрбум төгрөгөөр буюу 24.5 хувиар, эхний 8 сард **1,625.0** тэрбум төгрөгөөр буюу 23.1 хувиар, 3 дугаар улиралд **1,570.8** тэрбум төгрөгөөр буюу **20.0** хувиар дутуу зарцуулагдсан байна.

- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 2018 оны эхний 1 дүгээр улиралд **11.8** тэрбум, эхний хагас жилд **59.4** тэрбум, эхний 7 сард **93.0** тэрбум, эхний 8 сард **125.5** тэрбум, 3 дугаар улиралд **176.8** тэрбум төгрөгийн санхүүжилт гарчээ. Өөрөөр хэлбэл, 2018 онд санхүүжигдэх нийт 683.3 тэрбум төгрөг төлөвлөсний 79.5 хувийг эхний 9 сард зарцуулахаар төлөвлөсөн хэдий ч **32.5** хувийг л ашигласан байна. Эндээс үзэхэд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, түүний санхүүжилт удаашралтай байгаа нь харагдаж байна.
- Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үеэс 33.6 тэрбум төгрөг буюу 4.3 хувиар, тайлант хугацаанд төлөвлөсөн дүнгээс 136.8 тэрбум төгрөг буюу 15.5 хувиар бага зарцуулагдсан нь улсын төсөвт үзүүлэх зээлийн үйлчилгээний зардал буурах хандлагатай байгааг харуулж байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА